

САЙНЦАГААН СУМЫН “АЗ ЖАРГАЛТАЙ ИРГЭН “ДЭД ХӨТӨЛБӨРИЙН ХЭРЭГЖИЛТ

2019.11.22

№	Хөтөлбөр/төслийн агуулга	Гүйцэтгэл		
1.	Төсөл, хөтөлбөрийн нэр, огноо, шийдвэрийн дугаар (Жич: уялдаа холбоо бүхий дэд/төсөл, хөтөлбөр байвал нэгтгэн тайлагнана).	Сумын “Аз жаргалтай иргэн” дэд хөтөлбөрийг ИТХурлын 2018 оны 11 дүгээр тогтоолоор баталлаа. Дэд хөтөлбөрийн зорилго нь: Гэр бүлийн гишүүдийн нийгмийн оролцоог нэмэгдүүлж бүтээлч сэтгэлгээг хөгжүүлэх, хөгжил рүү тэмүүлсэн амьдралын идэвхид нөлөөлж өрх гэр бүлийн амьдралын чанарыг сайжруулах, бие хүний эрүүл байдлыг эрхэмлэн хүүхдэд ээлтэй орчинг бүрдүүлэх, өрхийн гишүүдийн боловсрол, мэдлэг чадварыг дээшлүүлж хөдөлмөр эрхлэх замаар өрхийн орлогыг нэмэгдүүлэхэд оршино.		
2.	Санхүүжилтийн эх үүсвэр	Сумын ЗДТГазрын хөрөнгө оруулалт /5 000 000/		
3.	Хэрэгжүүлэгч байгууллага/ хэрэгжих нийт хугацаа	Сумын ЗДТГазар, багууд		
4.	Төсөл, хөтөлбөрийн зорилтууд	Зорилт 1. Ажилтай орлоготой иргэн Зорилт 2. Бүтээлч иргэн Зорилт 3. Эрсдэлгүй амар тайван иргэн		
5.	Зардал	Төсөв (нийт шаардагдах зардал)	5 000 000	
		Үүнд:	Төсөв (2019 он)	Гүйцэтгэл
	Багц 1	1000000	1000000	100%
	Багц 2	1525900	1525900	100%
	Багц 3	1405650	1405650	100%
6.	Төсөл, хөтөлбөрийн зорилт:	Ажилтай орлоготой, бүтээлч сэтгэлгээтэй, эрсдэлгүй амар тайван иргэн		
	1-р зорилтын хүрээнд: Хүрэх үр дүн 1: Хөдөлмөр эрхлэлт ,нийгмийн хамгааллыг нэмэгдүүлэх ,мэргэжлийн чиг баримжаа олгох, хөдөлмөрийн чадамж олгох сургалтанд гэр бүлийн гишүүдийг хамруулах, иргэнийг ажлын байранд зуучлах/	Хөтөлбөрт нийт 65 өрхийн 287 иргэн хамрагдлаа. Үүнээс 139 том хүн, 148 хүүхэд байна. Нийт 139 том хүн байгаагаас тэтгэвэрт 3, оюутан 11, байнгын асаргаанд 5, ажил хийх боломжгүй 11, ажилтай иргэн 39, ажилгүй 70 иргэн байна. Үүнээс 52 иргэнийг ХХҮГазарт ажил идэвхтэй хайгч иргэнээр бүртгүүллээ. Ажил,хөдөлмөр эрхэлдэггүй 70 иргэнээс байнгын ажлын байранд 7,түр ажлын байранд 17, нийтийг хамарсан ажил 31 нийт 55 иргэнийг зуучиллаа. Нийт 6 өрхийг төсөл хөтөлбөрт, 42 өрхийг дэмжлэгт хамрууллаа.Үүнд: ХБИргэдийн ажлын байрыг дэмжих хөтөлбөрт 1 иргэн /5 сая/, малжуулах төсөлд 4 өрх/20 сая/, ажлын байрыг дэмжих хөтөлбөрт 1 иргэн /5 сая/. Хөтөлбөрийн өрхөөс 6 өрхөд гэр олгож /9сая/, 4 өрхийг хашаажуулж /1525900/, 1 иргэнийг хөдөлмөр эмнэлэгийн магадлах комиссын хурлаар хөгжлийн бэрхшээлийг тогтоон тэтгэмжид		

		<p>хамрууллаа. 10 өрхөд хувцасны дэмжлэг /150 мянга/, 21 өрхөд Эко усны савтай /337 мянга/ болгосноор 41 012 900 төгрөгөөр дэмжлээ.</p> <p>ХХҮГазартай хамтран 46 иргэнийг сургалтад хамрууллаа:Үүнд: Хөдөлмөрт бэлтгэх - 23, арьс ширэн эдлэл, бэлэг дурсгалын -8, аж ахуй эрхлэлтийн – 15</p>
	<p>2-р зорилтын хүрээнд: Хүрэх үр дүн 1: Бүтээлч иргэн / иргэдийн бүтээлч сэтгэлгээг нэмэгдүүлж, амьдрах орчинг сайжруулна/</p>	<p>Хөтөлбөрт хамрагдсан 65 өрхөөс өөрийн хашаандаа амьдарч байгаа 14 өрхийн хашааг зосдуулж, ОО болон хаалгыг будууллаа. Арвижих, Боржигон, Айраг, Мандал багуудаас олон хүүхэдтэй, өндөр настан болон хөгжлийн бэрхшээлтэй иргэнтэй, идэвхтэй, хөдөлмөрч 4 өрхийг сонгон, хашаа, хаалга, бие засах газрыг сайжруулах, тохижуулах ажлыг зохион байгууллаа. Тохижилтын ажилд 1.525.900 төгрөг зарцууллаа. Хот тохижуулах газар, ХЭДСангаас хэрэгжүүлж буй нийтийг хамарсан бүтээн байгуулалтын ажилд нийт 50 иргэнийг хамрууллаа. Үүнд: “Уяхан замба тивийн наран” урлагийн их наадамд-13 ,нийтийг хамарсан цэвэрлэгээнд- 31, оготоно устгалд – 5, байшин орон сууцны тооллогод- 1.</p> <p>Хөтөлбөрт хамрагдсан нийт 287 иргэнээс өмчлөлийн газартай 110, өмчлөлийн газаргүй 177 байна. 2 өрхийн өмчлөлийн газрыг шийдүүлж, хашаажууллаа.</p>
	<p>3-р зорилтын хүрээнд: Хүрэх үр дүн 1: Эрсдэлгүй амар тайван иргэн /Гэр бүлийн өмнө нэн тулгамдаж буй асуудлуудыг шийдвэрлэхэд эрх зүйн болон нийгмийн ажил үйлчилгээний тусламж үзүүлэх/</p>	<p>“Хүүхдийн хөгжил хамгаалалд эцэг эхийн оролцоо” зөвлөгөөнийг зохион байгууллаа. Зөвлөгөөнд 200 гаруй эцэг эх асран хамгаалагчид оролцож, хүүхдийн хөгжил хамгааллыг гэр бүл, сургууль цэцэрлэг, орон нутгийн орчинд хамгаалах хөгжүүлэхэд тулгамдаж буй асуудал, шийдвэрлэх арга замын талаар хэлэлцлээ. Зөвлөгөөнөөс иргэдийн гаргасан саналуудыг эрэмбэлэн 2020 онд хэрэгжүүлэх ажилд тусгаж, холбогдох байгууллагуудад зөвлөмж хүргүүлэхээр боллоо. /219350 төгрөг /</p> <p>“Сэтгэл зүйн дархлаажуулалт аяны хүрээнд сумын гэр бүлийг дэмжих туршилтын хөтөлбөрт хамрагдаж буй нийт 65 өрхийн 35 иргэнд хүний хөгжлийн лекц, сургалтыг зохион байгууллаа. Сургалтаар гэр бүлийн гишүүдийн үүрэг, оролцоо, асуудал шийдвэрлэх үр чадварыг орчин үеийн сэтгэл судлалын арга техник, монгол хүний ахуй соёл, сэтгэлгээний онцлогт тохируулан, тусгайлан бэлтгэгдсэн мэргэжлийн сэтгэл судлаачдын явуулын баг үр дүнтэй зохион байгууллаа. Мөн 2 хүүхэд ганцаарчилсан зөвлөгөө авч, сэтгэл зүйн оношилгоонд хамрагдлаа. /460900 төгрөг/</p> <p>Аймгийн ГБХЗХГазраас, гэр бүлд дулаан уур амьсгалыг бүрдүүлэх, олон улсын гэр бүлийг тэмдэглэн өнгөрүүлэх, хүүхдийг гэр бүлийн орчинд нь хамгаалах, эсэн мэнд амьдрах боломж нөхцлийг нь дэмжих, сэтгэл зүйн үйлчилгээ үзүүлэх, гэр бүлийн үнэ цэнийг нэмэгдүүлэх, байгууллагуудын гэр бүлийн зөвлөлийн үйл ажиллагааг дэмжих зорилгоор “Зөвлөө, Дэмжье, Хамтаръя” өдөрлөгийг зохион байгууллаа. Өдөрлөгийн хүрээнд: “Гэр бүлийн харилцаа, хүүхэд, хүмүүжлийн эерэг арга“, Өрхийн тэргүүний манлайлал” ,“Сайн аав-Сайн хань байх” ,“Гэр бүлийн эрүүл харилцаа” сэдэвт лекц сургалтыг хийлээ. Сургалтын үр дүнд: Өдөрлөгт хамрагдсан гэр бүлүүд үндэсний хэмжээнд зохион байгуулагдаж буй “ЗӨВ ТУСГАЛ” хөдөлгөөнд нэгдлээ. Амьдрах чадвар олгох 8 модуль, Хүүхдийн эрхийн тухай хууль, Хүүхэд хамгааллын тухай хууль, Гэр бүлийн хүчирхийллийн тухай хууль болон 8 сэдвийн хүрээнд сургуулийн нийгмийн ажилтнууд болон “Оюуны гэгээ” ТББайгууллага, ЭМГазар, Төрийн банктай хамтран зохион байгууллаа. Тус сургалтад “Аз жаргалтай иргэн” дэд хөтөлбөрийн 106 иргэн хамрагдлаа. /239400 төгрөг /</p>

		<p>Эрүүл мэндийн талаар: Хөтөлбөрт хамрагдсан 139 иргэнээс 114, 148 хүүхдээс 111 , нийт 225 иргэнийг үзлэг шинжилгээ, оношилгоонд хамрууллаа. Үүний үр дүнд: С вирустай 2 , В вирустай 6 , цөсний чулуутай 2 , элэг өөрчлөлттэй 1 , тэмбүүтэй 5 амьсгалын замын өвчлөлтэй 18 хүүхэд оношлогдож, 8 хүүхдийг эмнэлгийн магадлагаагаар гэрээр эмчиллээ. 1-р шатлалаас илэрсэн 3 иргэнийг 2-р шатлал буюу нарийн мэргэжилийн үзлэгт хамрууллаа. Бусад илэрсэн өвчлөлийг эмчилгээнд хамруулж эрүүлжүүлж байна. Судалгаагаар архины хамааралтай 9 иргэн байна. Үүнээс: АА-гийн сургалтад 1 иргэн хамрагдаж, архинаас бүрэн татгалзлаа. Мөн 1 иргэнийг үзлэг шинжилгээнд хамруулж архины хамаарлын түвшинг тогтоон албадан эмчилгээнд хамруулах шүүхийн шийдвэр гаргуулахаар боллоо. Хөтөлбөрийн 148 хүүхдээс ЕБСургуульд 93, цэцэрлэгт 35 , гэрээр 20 хүмүүжиж байна. Цэцэрлэг завсардсан 1 хүүхдийг цэцэрлэгт хамрууллаа. ЕБСургуулийн 93 сурагч байгаагаас дугуйлан секцд хамрагддаг 11, хамрагддаггүй 82 сурагч байна. Үүнээс хамрагдах сонирхолтой 38 сурагчийг волейбол – 15 , дууны дугуйлан- 9, шатар- 5 ,морин хуур – 3 ,бүжигт -6 хүүхдийг дугуйлан секц хамрууллаа. Өрх иргэдийн чөлөөт цагийг зөв боловсон өнгөрүүлэх, гэр бүлийн харилцаанд эерэг өөрчлөлт хандлага олгох зорилгоор тэмцээн зохион байгуулж, нийт 55 иргэн,хүүхэд оролцлоо. Шагналд 439500 төгрөг зарцууллаа.</p>				
7.	Дүгнэлт (ололт, дутагдал, анхаарах асуудлууд)	<p>Ололттой тал: Сумын дэд хөтөлбөрийг хэрэгжүүлснээр өрх иргэдийн амьдралд тодорхой үр дүн гарч, зарим өрхийн орлого нэмэгдэн, орон нутгийн төр захиргааны байгууллагын үйл ажиллагаанд оролцох, санал бодлоо нээлттэй илэрхийлэх боломж нээгдсэн байна. Дутагдал: Иргэдийн хандлага идэвх оролцоо сул, бэлэнчлэх сэтгэлгээтэй, ажилд дургүй ажлыг голж шилдэг.</p>				
8.	Төсөл, хөтөлбөрийг хэрэгжүүлэгч талуудын хамтын ажиллагаанд өгөх хөндлөнгийн үнэлгээ	<p>Хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд ажлын хэсгийн гишүүд ялангуяа багийн нийгмийн ажилтнууд онцгой үүрэгтэй ажилласан нь үр дүн гарахад нөлөөллөө.</p>				
9.	Төсөл, хөтөлбөрийн хэрэгжилтийн үнэлгээ, дүгнэлт (өөрийн үнэлгээ)	Биелэлт дундаж 97,69 %	Зорилтын тоо 3	Зорилт 1 100 %	Зорилт 2 100 %	Зорилт 3 95%
10.	Төсөл, хөтөлбөрийн хэрэгжилтийн нэгдсэн үнэлгээ (ЗГХЭГ-ын үнэлгээ)	<p>Нэгдсэн үнэлгээ%</p>				

САЙНЦАГААН СУМЫН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР